



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 15 өдөр

Дугаар A/232

Булган сум

Г Орхон сумын Эрүүл мэндийн төвийн барилгыг хүлээн авах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.5 дахь заалт, “Эд хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай” 2024 оны 671, 2025 оны 128 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн Булган аймгийн Орхон сумын Эрүүл мэндийн төвийн 2,293,300,000 (хоёр тэрбум хоёр зуун ерэн гурван сая гурван зуун мянга) төгрөгийн барилгыг хүлээн авах, бүртгэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:  
Гишүүд:

О.Ундрах (Аймгийн Засаг даргын орлогч)  
М.Батчимэг(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Т.Баттулга (Орон нутгийн өмчийн газрын дарга)  
П.Оюунцэцэг (Эрүүл мэндийн газрын дарга)  
Х.Ундрахбаяр (Орхон сумын Засаг дарга)

Ж.Эрдэнэбулган (Онцгой байдлын газрын Гал түймрийн улсын хяналтын байцаагч, ахмад)

Г.Ганзориг (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн дарга)

Г.Отгонням (Орхон сумын Эрүүл мэндийн төвийн дарга)

Д.Уламбаяр (Орон нутгийн өмчийн газрын Өмчийн бүртгэл ашиглалт хариуцсан ахлах мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:

2. Барилга байгууламжийг барьж ашиглалтад оруулсан хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан улсын комиссын акт холбогдох баримтыг баталгаажуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (О.Ундрах)-д даалгасугай.

3. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу эзэмшигч байгууллагын нягтлан бodoх бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим системд”-д бүртгэхийг Орон нутгийн өмчийн газрын дарга (Т.Баттулга)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПУРЭВ-ОЧИР

Sugar Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж

6325010338

ХАРХАГДАА